

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/80/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дархан-Уул аймаг

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:

Утас: 70378845

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 70373089


Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Э.Эрдэнэбат

Утас: 99352099

Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.




АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага.....	18
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт





**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ
СУМЫН 14 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ С.ОТГОНПҮРЭВ ТАНАА

2025.02.25 № 73

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл


Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайланд онд Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 13,408.5 мянган төгрөгийн зөөврийн компьютер, Шарын гол сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 25,000.0 мянган төгрөгийн эко модон тоглоомын талбай, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 2,486.3 мянган төгрөгийн телевизор, Шарын гол ХК-ийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн 79,800.0 төгрөгийн дулаан хангамжийн шугамыг үнэ төлбөргүй хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.



Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 928,693.5 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 39.8 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 52 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 100 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР






АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан


Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	112,101,754.69	174,717,013.72
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	47,320,065.33	79,788,348.36
31211	Төрийн сангийн харилцах	47,320,065.33	79,788,348.36
35	БАРАА МАТЕРИАЛ	64,781,689.36	94,928,665.36
351	Түүхий эд материал	618,395.00	414,600.00
3513	Эм боох материал	618,395.00	414,600.00
354	Хангамжийн материал	64,163,294.36	94,514,065.36
35410	Бичиг хэргийн материал	542,000.00	842,000.00
35420	Аж ахуйн материал	33,835,832.36	65,156,227.36
3545	Барилгын засварын материал	22,833,000.00	23,118,000.00
3546	Хүнсний материал	4,801,262.00	3,742,638.00
35470	Бусад хангамжийн материал	2,151,200.00	1,655,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	711,604,024.87	813,707,394.11
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	711,604,024.87	813,707,394.11
392	Биет хөрөнгө	700,729,487.51	802,832,856.75
39201	Барилга, байгууламж орон сууц	697,013,662.46	775,241,742.46
39202	Хуримтлагдсан элэгдэл	(53,252,367.97)	(65,766,272.29)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	41,900,389.20	58,489,269.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(23,639,013.97)	(22,595,160.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,753,297.00	46,139,297.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,497,033.92)	(15,126,573.42)
39209	Бусад үндсэн хөрөнгө	7,583,540.06	32,583,540.06
39210	Хуримтлагдсан элэгдэл	(7,509,565.35)	(7,509,565.35)
39217	Ном	1,376,580.00	1,376,580.00
393	Биет бус хөрөнгө	10,874,537.36	10,874,537.36
39301	Программ хангамж	2,253,800.00	2,253,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,113,262.64)	(2,113,262.64)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,734,000.00	10,734,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	823,705,779.56	988,424,407.83
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	823,705,779.56	988,424,407.83
51	Засгийн газрын хувь оролцоо	823,705,779.56	988,424,407.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	162,018,567.05	162,018,567.05
51101	Өмч: - төрийн	162,018,567.05	162,018,567.05
512	Хуримтлагдсан үр дүн	104,947,336.03	269,665,964.30
51210	Өмнөх үеийн үр дүн	104,947,336.03	104,947,336.03
51220	Тайлант үеийн үр дүн	-	164,718,628.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	556,739,876.48	556,739,876.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	823,705,779.56	988,424,407.83




2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан


/төгрөгөөр/


Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	726,006,313.20	1,070,635,860.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,091,313.20	143,393,360.00
120	Нийтлэг татварын бус орлого	68,091,313.20	143,393,360.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	61,336,213.20	124,393,360.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	6,755,100.00	19,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	657,915,000.00	927,242,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	552,045,000.00	817,712,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	105,870,000.00	109,530,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	105,870,000.00	109,530,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	619,933,207.83	905,917,231.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	619,933,207.83	905,917,231.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	616,993,443.68	893,545,111.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	392,289,467.00	612,094,629.91
210101	Үндсэн цалин	274,635,623.47	399,459,420.91
210102	Нэмэгдэл	96,232,393.53	186,216,357.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	21,421,450.00	26,418,852.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,454,773.86	78,303,642.06
210201	Тэтгэврийн даатгал	33,139,142.54	53,259,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,828,807.91	6,265,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,063,366.33	3,132,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	765,641.25	3,132,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,657,815.83	12,512,542.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,485,735.85	101,524,779.31
210301	Гэрэл, цахилгаан	7,304,134.65	6,390,096.68
210302	Түлш, халаалт	75,425,407.85	81,471,468.62
210303	Цэвэр, бохир ус	8,756,193.35	13,663,214.01
210304	байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	5,477,540.00	1,213,000.00
210401	Бичиг хэрэг	3,486,100.00	717,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-



210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,991,440.00	496,000.00
210408	Бараа материал акталсны зардал	-	-
2105	Нормативт зардал	44,353,902.00	50,845,214.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	185,345.00	123,795.00
210502	Хоол, хүнс	43,007,557.00	50,721,419.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,161,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	974,800.00	4,008,620.00
210601	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	974,800.00	4,008,620.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоод албан томилолт	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	870,617.40	1,450,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	-
210805	тээврийн хэрэгслийн оношлогоо	-	-
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	870,617.40	1,450,000.00
210807	Газрын төлбөр	-	-
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,086,607.57	44,105,225.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,739,160.00	12,431,235.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	6,268,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,347,447.57	25,405,690.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,939,764.15	12,372,120.69
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,853,800.00	12,364,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,853,800.00	12,364,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	85,964.15	8,020.69
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	85,964.15	8,020.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	106,073,105.37	164,718,628.27
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	106,073,105.37	164,718,628.27








210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	0.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-
2105	Нормативт зардал	45,673,775.00	49,662,795.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	45,673,775.00	49,662,795.00
2106	Эд хогшил урсгал засвар	14,298,300.00	7,997,200.00
210601	Багаж техник хэрэгсэл	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	14,298,300.00	7,997,200.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоодын томилолт	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	870,617.40	2,100,000.00
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	870,617.40	2,100,000.00
210807	Газрын төлбөр	0.00	0.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,876,700.00	27,603,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,242,700.00	21,430,650.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	2,634,000.00	6,172,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,939,764.15	12,372,120.69
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,853,800.00	12,364,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,853,800.00	12,364,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт , шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	85,964.15	8,020.69
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	85,964.15	8,020.69
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	45,025,866.74	35,583,983.03
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн	-	-
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	-	(3,115,700.00)
0	Дотоод эх үүсвэр	-	3,115,700.00
223001	Бусад хөрөнгө	-	-
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	45,025,866.74	32,468,283.03
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,294,198.59	47,320,065.33
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	47,320,065.33	79,788,348.36







2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	162,018,567.05	556,739,876.48	(1,125,769.34)	-	717,632,674.19
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	162,018,567.05	556,739,876.48	(1,125,769.34)		717,632,674.19
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			106,073,105.37		106,073,105.37
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	162,018,567.05	556,739,876.48	104,947,336.03	-	823,705,779.56
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	162,018,567.05	556,739,876.48	104,947,336.03		823,705,779.56
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D07	Тайлант үеийн үр дүн			164,718,628.27		164,718,628.27
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	162,018,567.05	556,739,876.48	269,665,964.30	-	988,424,407.83








210807	Газрын төлбөр		0.00		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,113,100.00	30,719,050.00	(3,394,050.00)	90.1%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,931,100.00	24,546,350.00	(3,384,750.00)	87.9%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,182,000.00	6,172,700.00	(9,300.00)	99.8%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,364,100.00	12,364,100.00	-	100.0%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	
213101	Засгийн газрын дотоод урсгал шилжүүлэг				
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,364,100.00	12,364,100.00	-	100.0%
213204	ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал				
213208	хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг				
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	12,364,100.00	12,364,100.00		100.0%
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг				
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг				
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох				
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг				
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг				
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг				
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-		
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	944,412,500.00	927,234,479.31	(17,178,020.69)	98.2%
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,000,000.00	5,000,000.00		100.0%
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	812,712,500.00	812,712,500.00		100.0%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	126,700,000.00	109,521,979.31	(17,178,020.69)	86.4%
132001	Орон нутгийн төсвөөс	126,700,000.00	109,521,979.31	(17,178,020.69)	86.4%
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		47,320,065.33		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		79,788,348.36		
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
3	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	28.00	-	100.00
	Удирдах ажилтан	1.00	1.00		100.00
	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00		100.00
	Үйлчлэх ажилтан	10.00	10.00		100.00

11

ХТӨС 0100 00000000



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан Уул аймгийн Шарын гол сумын 14 дүгээр цэцэрлэг нь “Хүүхдийн авьяас билэг, хэрэгцээ сонирхолд нийцсэн сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, хүүхэд тоглох явцдаа өөрөө суралцан бүтээлч үйлээрээ хөгжих орчин нөхцөлийг бий болгоход оршино” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийн тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:


- “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоолоор
- “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоолоор
- “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоолоор
- “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 82 тоот тогтоолоор
- “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш ажилтанд мөнгөн тэтгэмж олгох” журам Монгол улсын Засгийн газрын 2024 оны 104 тоот тогтоолоор
- “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол Монгол улсын Засгийн газрын 2024 оны 237 тоот тогтоолоор
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамратсан 2024 оны А/85, А/34 тоот “Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай” тушаал
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамратсан 2024 оны 115 тоот “Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх дүгнэх” тушаал

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ



илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Шарын гол сумын 14 дүгээр цэцэрлэг 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Шарын гол сумын 14-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС -ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 164,718.6 мянган төгрөгөөр буюу 19.9 хувиар өссөн байна.


Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	47,320.1	79,788.3	32,468.3
Бараа материал	64,781.7	94,928.7	30,147.0
Үндсэн хөрөнгө	711,604.0	813,707.4	102,103.4
Нийт хөрөнгө	823,705.8	988,424.4	164,718.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	823,705.8	988,424.4	164,718.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	823,705.8	988,424.4	164,718.6

Тайлант онд төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 79,788.3 мянган төгрөг байна

Бараа материалын дансны үлдэгдэл 94,928.7 мянган төгрөг болж 30,147.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 82,339.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 19,000.0 мянган төгрөгийн Steam тоглоомыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 71,192.4 мянган төгрөгийн материалыг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 1,655.2 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, 65,156.2 мянган төгрөгийн аж ахуйн материал, 842.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 3,742.6 мянган төгрөгийн хүнсний материал, 414.6 мянган төгрөгийн эм боох материал, 23,118.0 мянган төгрөгийн барилгын засварын материал зэрэг үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 813,707.4 мянган төгрөг болж 102,103.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 3,115.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, Дархан-Уул аймгийн Засаг даргын 01-А/524 тоот захирамжаар 13,408.5 мянган төгрөгийн зөөврийн компьютер, Шарын гол сумын ИТХ-ын 2024 оны 12 тоот тогтоолоор



25,000.0 мянган төгрөгийн эко модон тоглоомын талбай, БЕГ-ын хөрөнгө оруулалтаар 2,486.3 мянган төгрөгийн телевизор, Шарын гол сумын ИТХ-ын 51 тоот тогтоолоор нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн 79,800.0 төгрөгийн дулаан хангамжийн шугамыг тус тус орлогоор бүртгэж, ОНӨГ-ын 2025 оны А/02 тоот тушаалаар элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг 7,306.1 мянган төгрөгөөр дахин үнэлж, тайлант онд 25,405.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 528,496.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 126,700.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 655,196.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2024 оны орон нутгийн төсвийг 126,700.0 мянган төгрөг, Төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор улсын төсвөөс 865,032.1 мянган төгрөг болгон нэмэгдүүлж нийт 991,732.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.


3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 817,712.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 109,521.9 мянган төгрөг буюу нийт 927,234.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг олгосноос зарцуулаагүй үлдсэн 32,468.3 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 894,766.2 мянган төгрөг буюу 94.7% хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 49,646.3 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.1	81605-Эрүүл мэндийг дэмжих	2,383.7	1,220.0	(1,163.7)	51.2%
1.2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	59,342.2	49,662.7	(9,679.5)	83.7%
1.3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,791.4	2,790.0	(1.4)	99.9%
1.4	81823-Боловсролын байгууллагын багш,ажилтны мэргэжил дээшлүүлэх	1,427.7	820.0	(607.7)	57.4%
1.5	81834-Боловсролын стандарт	729,787.9	694,232.1	(35,555.8)	95.1%
1.6	80233 -Хүүхэд хамгаалал	926.8	926.0	(0.8)	99.9%
1.7	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	33,222.8	30,593.5	(2,629.3)	92.1%
1.8	83603-Дээд шатны төсвөөс ху	5,000.0	5,000.0	-	100.0%
	71801-Сургуулийн өмнөх боловсрол	834,882.5	785,244.3	(49,638.2)	
2	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	109,530.0	109,521.9	(8.1)	100.0%
	Нийт дүн	944,412.5	894,766.2	(49,646.3)	94.7%



Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус цэцэрлэг нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 17 ажилтан, үйлчлэх 10 ажилтан буюу нийт 28 ажилтантайгаар ажиллаж, 210901-Бараа үйлчилгээний бусад зардалд 12,431.2 мянган төгрөгийг зарцуулж, тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН


4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Шарын гол сумын 14-р цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын Шилэн дансны тухай хууль, Ахмадын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Э.Эрдэнэбат гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Шарын гол сумын 14-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн.



4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 619,933.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,199.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дархан Уул аймгийн Шарын гол сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс 4 мэдээллийг хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь:


Шилэн дансны системд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж хүргүүлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан” байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан



байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус цэцэрлэгийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар илэрсэн нийт 215.4 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн биелэлтийг шалгахад 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	215.4	1	215.4	100
Нийт дүн	1	215.4	1	215.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр баталсан 528,496.1 мянган төгрөгийн төсвийн хуваарийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 284,216.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 159,757.9 мянган төгрөг төвлөрсөн тул харилцах дансны үлдэгдэл өсөж төсвийн гүйцэтгэл 94.7 хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,115.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрсэн тул дараах байдлаар залруулав Үүнд:


- Тайланд онд өөрийн хөрөнгөөр худалдаж авсан 3,115.0 мянган төгрөгийн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим" 5.1.4. "үнэн зөв байх" заалт, УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", санхүүгийн тайлангийн аудитын "Ангилал", "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгө оруулалтын зардлаар бүртгэж залруулав.

Мөн аудитаар нийт 3,197.2 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул төсвийг хохиролгүй болгох 109.2 мянган төгрөгийн төлбөрийн акт, 3,088.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/



Хүүхдийн хоолны махны норматив хэмжээг 109.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1.Илрүүлэлт: Тайлант онд 3,088.0 мянган төгрөгийн балансын урамшуулал авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тогтоолын “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-тай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.


5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмж байхгүй.

Дээрх зөвлөмж болон 4.4.1, 4.4.2 дахь хэсэгт дурдсан Шилэн дансны тухай хууль, Ахмад настны тухай хуулийн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ




6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/									
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн
Тайланд онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3,115.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны мөнгөн зардлаар тайлагнасан.	1	3,115.0	-	-	-	-	1	3,115.0	-	-
Дүн	1	3,115.0	-	-	-	-	1	3,115.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хүүхдийн хоолны махны норматив хэмжээг 109.1 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.	1	109.1	1	109.1	-	-	-	-	-	-	-	-
Тус цэцэрлэгийн эрхлэгч С.Отгонпүрэвийг Дархан-Уул аймгийн БГ-ын даргын А/141 тоот тушаалаар 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр "өөрчлөлтгүй" гэж дүгнэгдсэнд нэг сарын цалин 2 дахин нэмэгдүүлэн 3,088.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.	1	3,088.0	1	3,088.0	1	3,088.0	-	-	-	-	-	-
Дүн	2	3,197.1	1	109.1	1	3,088.0	-	-	-	-	-	-



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим системд, байгууллагын батлагдсан төсөв мэдээлэлийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-	-	-	1	-
Тус цэцэрлэг нь Ахмад настны тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна.	1	-	-	-	1	-
Дүн	2	-	-	-	2	-

